

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Норжингийн Даваажаргал	Дугаар	L133
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сүм	Онгон
Төрсөн газар		Төрсөн он	
Ажил мэргэжил	Онгон сумын Жамцолин хийдийн тэргүүн		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Их булгийн хийд	Сүм хийдийн дугаар	СБОН 014
Одоогийн сүм хийд	Жамцолин хийд	Сүм хийдийн дугаар	СБОН 015
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 27	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Онгон сумын Их булгийн хийд, Жамцолин хийд

Эх булгийн хийдийг үе үед хувилгаадүүд толгойлж байсан хийд байна.

Хамгийн сүүлийн хамба нь Баяндэлгэр сумын харъяат Дамбийжанцан гэдэг хүн байгаад одоо энэ 30 хэдэн оны үед хэлмэгдсэн. Байнга суудаг 30гаруй ламтай хөдөөх ламтайгаа 200 гаруй ламтай байсан гэдэг.Богдод мэдээтэй чийга, ямпайтай, орлогоосоо хувь явуулдаг тийм сүм байсан гэсэн. Хамгийн сүүлд Чадраа гэдэг хувилгаан байж байгаад баригдсан гэсэн.

-Их булгийн хийд маань хэдэн дугантай байсан бэ?

Лав л гурван дугантай байсан байгаа юм. Цогчэн дуган, Манба, Зурхайн дацан гэж 3 дугантай байсан.Жастай байсан. Эх булгийн гүртэн гэж маш чадалтай хүн байсан гэдэг.Дээр үед гүртэнгүүд гэж их чадалтай улсууд байсан юм шиг байгаа юм. Сэлэм зангиддаг, сүмийхээ ханаар гараад явчихдаг ороод ирдэг, эрүү амаа заачихдаг гэх мэт. Ерийн нөхцөлд зүгээр энгийн хар хүн архи ууж, авгай дагуулсан хүн байсан гэсэн. Сүүлийнх нь лав.

-Их булгийн хийдийг ямар хүн байгуулсан юм бол?

За одоо тэрийг бол бүү мэд. Энэ хийд 1700-аад оны үед байгуулагдсан юм болов уу. Дарьгангын анхны 11 сүмийн нэг гэдэг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Энэ сүмийн үнзэд байсан Базар гэдэг хүн 2000 онд таалал төгссөн. Тэр хүн л сүмийн талаар жаахан юм ярьдаг байсан. Түүний үр хүүхдүүд нь Дарьгангад байдаг байх. Эх булгийн хийдэд тахилч байсан нэг хүн сүүлд Овоон сүмийн үнзэд ламаар хурж байгаад өөд болсон.

-Эх булгийн хийд маань ямар хийдүүдтэй холбоотой байсан юм бол?

Эх булгийн хийд Молцогийн хийдтэй холбоотой байсан. Эрдэнэцагааны Дамдинбишрэлт энэ хавийн бүх л хийдүүдээр явж байсан. Би багштайгаа багш шавь болоод төвд үсэг заалгаад. Манай багш гэгцэл Содов гэдэг хүн. Манай багш Дарьганга Асгат талын хүн. Өвөрмонгол руу гарсан байж байгаад 1945 онд 13 настайдаа буцаж ирсэн гэдэг. Онгон сумд Гэлэг гүүш гэдэг лут хүн гаднаас орж ирсэн байсан тэр хүний шавь гэсэн.

Эх булгийн сүм нь 1995 оны 06 сарын 08 нд дахин сэргээн байгуулагдсан

-Шинэ хийдийг сэргээхэд хэн хэн оролцсон бэ?

Уваа, Өлзийхутаг, Дорждэрэм нарын санаачлага тухайн үеийн засаг дарга байсан Бадарчин, хурлын дарга байсан Болдоо нарын дэмжлэгээр Бадарчин даргын гэрийг бариад 1995 онд байгуулагдаж байсан. Тэр үедээ багш бид хоёр 7 хүүхэдтэй нийт 9-үүл байсан.

-Хийд сэргээгдсэнээс хойш хийдэд ямар ямар онцлог үйл явдал болсон бэ? 1995 онд Гурдаваа Ренбүүчий заларч сургаал номоо айлдсан. 1998 онд энэ дуганыг барьсан. 2000 онд Ганжуур залсан. 2004 онд суваргаа бүтээсэн. 2005 онд Жасын барилгыг барьсан. Сумдын хэмжээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

-Шавь нараас Энэтхэг, Төвдөд сургуульд явсан хүн байгаа юу?

Энэтхэгт нэг шавь 2 жил сураад ирсэн уг нь 6 жил сурах байсан. Шашны сургуульд 2 хүүхэд сурч байгаа. Манба дацанд нэг хүн байгаа.

-Хийдийн хурал номын тухай?

Өдөр тутам Цогчэн хуралтай, айлтгалтай. Жилдээ хавар, намартаа Санжид моломоо хурдаг. Шинийн 8,15,29-ны дүйчэн өдрүүдэд хуралтай. 8-нд Зургаан ерөөл, Оройн ерөөл, 15-нд Сандуйн жүд, 29-нд тахилгуудаа хурдаг.